



Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын сургуулийн сонсогч, ахлах дэслэгч Д.Чинзориг

ХОРИХ АНГИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТ, ТҮҮНД АШИГЛАЖ БУЙ ХАМГААЛАЛТЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТАЛААР

Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад ихээхэн хувь нэмэр үзүүлдэг алба нь хорих ангийн харуул хамгаалалтын алба юм. Хорих ангийн харуул хамгаалалтын алба нь анх гяндан салаа үүссэн тэр цагаас хойш өнөөг хүртлэх 90 гаруй жилийнхээ түүхэн хугацаанд тухайн цаг үе, нийгмийнхээ хөгжилд нийцүүлэн үйл ажиллагаагаа өргөтгөж өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгож ирсэн юм.

Хорих ангийн харуул хамгаалалтын гол хүч нь харуулын офицер, хянагч нар байдаг. Хорих байгууллагын түүхээс үзэхэд: *Хорих ангийн харуул хамгаалалтын алба нь ялтийг олон нийтээс тусгаарлан тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, үйлдсэн хэргийг илрүүлэх, таслан зогсоох, холбогдох хууль, хорих анги болон ялтны аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын өмнө хариуцдаг.*

Харуул хамгаалалтын ажлыг хорих ангийн дарга, харуул хамгаалалт, гүйцэтгэх алба эрхэлсэн дэд дарга нар өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж, харуул хамгаалалтыг боловсронгуй болгох ажлыг

нэгтгэн зохион байгуулдаг. Хорих ангийн дарга харуул хамгаалалтыг дараах төрлөөр зохион байгуулна. /Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журмын 2.3/

Үүнд:

- Байнгын хамгаалалт /ердийн буюу өдөр тутмын/
- Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих
- Хүч нэмэгдүүлсэн хамгаалалт
- Ялтны гаргасан ноцтой гэмт үйлдэл /бусдыг барьцаанд авах, зохион байгуулалттайгаар хорих ангийн дотоод журам зөрчих, захиргааны шаардлагд захирагдахгүй байх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгох, оргох/-ийг таслан зогсоох, эрэн сурвалжлах ажиллагаа зэрэг 4 төрлөөр зохион байгуулах бөгөөд эдгээр хамгаалалтын төрлүүдийг дэлгэрүүлэн авч үзье.

Хорих ангийн байнгын хамгаалалт /ердийн буюу өдөр тутмын/-ыг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, Хорих ангийн дотоод журам, тэдгээрт нийцүүлэн гаргасан хорих ангийн даргын тушаалын дагуу зохион байгуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хүч нэмэгдүүлсэн харуулыг томилон үүрэг гүйцэтгэж болно.

Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих -Улс орны гадаад, дотоод байдал хүндэрсэн, байгалийн гамшиг тохиолдсон, нийтийг хамарсан хорио цээрийн дэглэм тогтоосон, түүнчлэн нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд болон хорих ангид бий болсон онцгой учрал, нөхцөл байдлын үед Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын тушаалаар хүчлэн хамгаалалт /өндөржүүлсэн байдалд шилжих/-ыг зарлан ажиллах бөгөөд уг хамгаалалтын үргэлжлэх хугацаа, авч хэрэгжүүлэх арга хэмжээ түүнчлэн албаны бэлэн байдлыг хэрхэн хангаж ажиллах талаар тушаалд зааж өгнө.



Хүч нэмэгдүүлсэн хамгаалалт Ажлын шаардлага, албаны сургалт, дадлагын үед Хорих ангийн даргын тушаалаар тухайн хорих ангийн хэмжээнд “Хүчлэн хамгаалалт” зарласан тушаалд түүний үргэлжлэх хугацаа, эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, тухайн хугацаанд мөрдөгдөх дотоод цагийн хуваарь, ялтанд хяналт тавих, гадна хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах /чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд/ тухай болон хорих ангийн хариуцлагатай эргүүл, жижүүрийн бүрэлдэхүүний томилгоог тодорхой тусгана.

“Хүчлэн хамгаалалт”-ын хугацаанд ялтныг хорих ангийн хамгаалалтын бүсэд төвлөрүүлэн тэдний зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох албан тушаалтнууд авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Жирийн дэглэмтэй хорих ангийн алслагдсан хэсэг, салбарт шаардлагатай гэж үзвэл Хорих ангийн даргын шийдвэрээр хүчлэн хамгаалалт зарлаж болно. Энэ тохиолдолд хорих ангийг хариуцан ажилладаг хорих ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих эрх бүхий Прокурорын зөвшөөрлийг бичгээр авсан байвал зохино.

Хорих ангийн харуул хамгаалалтыг тухайн хорих ангийн дэглэм, ялтны тоо, байршил, албан хаагчдын орон тоо, ажил үүрэг гүйцэтгэж байгаа бэлэн хүч, тэдний зохион байгуулалт, албан хаагчдын эзэмшилд байгаа холбоо, дохиолол болон хамгаалалтын хэрэгсэл, галт зэвсэг, хүн нэг бүрийн тусгай хэрэгсэл, үйлдвэрлэлийн ба газар нутгийн онцлог, улс орны гадаад дотоод нөхцөл байдал, цаг агаарын онцлог зэргийг харгалзан

- дотоодын хамгаалалт;

- гадна хамгаалалт гэсэн үндсэн 2 хэлбэрээр хорих ангийн алба хаагчид, бусад хүч хэрэгсэл, цагдаа, дотоодын цэрэг, шаардлагатай тохиолдолд харьяалах нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагын хүч хэрэгсэл, дэмжлэгтэйгээр зохион байгуулна.

Хамгаалалтын хүч хэрэгсэл гэдэгт:

- хорих ангийн харуул хамгаалалтын болон бусад мэргэжлийн ажилтнууд;
- галт зэвсэг, /АКМ, ПМ, СВД гэх мэт/;
- тусгай хэрэгсэл, /Гар, хөл, хурууны гав, дөнгө, ороох цамц, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, резинэн болон хуванцар сумтай буу гэх мэт/;
- инженерийн байгууламж /телекамер/ хяналт тавих бусад хэрэгсэл/;
- хамгаалалтын бүс, тэдгээрийн техник тоног төхөөрөмж, /Дотоодын хориотой бүс, үндсэн хашаа, цахилгаан дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс, нохой гүйх бүс гэх мэт/;
- албаны нохой;
- онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй бусад ажиллагааг хамруулан ойлгоно.

Хорих ангийн хамгаалалтын хориотой бүс


Хорих ангийн хамгаалалтын хориотой бүсийг 1993 онд батлагдсан “Хорих ял эдлүүлэх тухай хууль”-д анхлан тусгаж өгсөн байдаг.

Уг бүсийг тогтоож өгсөн нь ялтныг нийгмээс тусгаарлаж, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, ялтан оргон зайлах, ялтныг гадны нөлөөллөөс хамгаалах, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх мөн хорих



ангийн аюулгүй байдлыг хангахад өндөр ач холбогдолтой зүйл болсон юм. Хуулийг хэрэгжүүлж эхэлснээр ял эдэлж буй ялтнуудын дундаас оргох гэмт хэрэг жил

ирэх тусам буурсаар байгаа нь дараах судалгаанаас харагдаж байна.



Хамгаалалтын бүс гэдэгт хорих ангийн амьдралын болон үйлдвэрлэлийн бүс, тэдгээрийн техник тоног төхөөрөмж, инженерийн байгууламж, ялтны түр болон байнгын ажиллах хэсэг, хорих ангийн салбарын байр, үйлдвэрлэлийн талбайг тойруулан тогтоосон хорих ангийн хориотой бүс, ялтныг автомашин, галт тэрэг, онгоцоор хуяглан хүргэх, тээвэрлэх болон тухайн хэрэгслийг тус тус хамруулан ойлгоно.

Жирийн дэглэмтэй хорих ангийн амьдралын болон үйлдвэрлэлийн бүсээс 1500-2000 метр зайд хориотой бүсийг байгуулах ба энэ шийдвэрийг тухайн орон нутгийн Засаг дарга гаргах, түүнчлэн хориотой бүсийг 2 метр өндөртэй өргөст тороор хашаалах бөгөөд мөр хоорондын зайг 12-15 сантиметр байхаар тогтоосон байдаг боловч энэ нь бодит амьдрал дээр хэрэгждэггүй явдал түгээмэл байна.

Хориотой бүсийн эргэн тойронд Монгол, Орос, Хятад, Англи хэлээр **“АНХААР ХОРИОТОЙ БҮС”** гэсэн сануулгыг өдөр шөнийн аль ч цагт харагдахуйцаар гаргацтай бичиж байршуулна гэжээ.

Телекамерийн хяналтыг сайжруулсанаар ялтны дундаас гарах зөрчил буурч зөрчлийг нөхөн илрүүлэлт сайжирсан байна. 2012 онд ялтны гаргасан зөрчлийг өнгөөр нь ангилж тэдгээр зөрчил гаргасан ялтнуудад ногдуулсан сахилгын шийтгэлийн судалгааг үзвэл:



**2012 ОНД ХОРИХ АНГИУДАД ЯЛ
ЭДЭЛЖ БАЙГАА ЯЛТНУУДЫН
ГАРГАСАН ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА**

д/д	Анги	Гаргасан зөрчил										Бүгд		Авсан арга хэмжээ					Бүгд
		ажил хийхээс тайлсхийсэн	ажлын талбай, хорих томилог дүр мэдэн явсан	бусдын дарамтатгал, да зүйл буцаасан	Бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан	бусдын биед гэмтэл учруулсан	арин уусан	хуулийн хийсэн	хоригтой тоглоом тогложсон	Албан хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн	Гар утас	бусад		ээжийн бус ажил хийлгэх	Хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх сахилтат байранд хорих	шигшээний хоног хасгах			
1	НХА-401									1	3	1	5	2		3		5	
2	Авдварант-403						2				12	3	17	4		12	1	17	
3	Ташир-405										1	3	4			3	1	4	
4	Баянзүрх-407									2	3	14	19	3	5	4	7	19	
5	Тоосго-409								1	2	9	5	17	9	1	6	1	17	
6	НХХА-411									1			1			1		1	
7	Зүүнхараа-413						7				60	1	68	33	2	27	6	68	
8	Мааньт-415					1				2	8	10	21	2	2	15	2	21	
9	Монголморьт-417						5				17		22	13	4		5	22	
10	Хэнтий-419										31		31	25		6		31	
11	Амгалан-421						2			2	9	3	16	3		2	11	16	
12	Хархорин-423		2		1		2				12	1	18	6		2	10	18	
13	Говьсүмбэр-425									3	25	6	34	21		13		34	
14	Багануур-427									1	103	11	115	51	1	57	6	115	
15	СЭА-429												0					0	
16	Дарьт-433						6				25	1	32	19	1	8	4	32	
17	Дархан-Уул-435								8	3	3		14	5		9		14	
18	Булган-439	2								3	1	4	10	4	2	2	2	10	
19	Хөвсгөл-443				1		4	1			1		7	1		2	4	7	
20	Ховд-457									1	1		2		1	1		2	
21	ЦХ-461/аж ахуй/										1	2	3			1	2	3	
22	Дарь-Эх-441						17			3		4	24			20	4	24	
23	Хонгор - 431												0					0	
24	Дархан-445	1			1						6		8	7		1		8	
25	Орхон-437				1							2	3	3				3	
	БҮГД	3	2	0	4	1	28	1	9	21	336	69	474	214	19	179	62	474	
	БҮГД	0	2	13	5	21	90	0	17	51	768	149	1116	560	91	331	134	1116	
		3	4	13	9	22	118	1	26	72	1104	218	1590	774	110	510	196	1590	
	БҮГД	0	0	0	1	4	13	0	0	11	47	17	93	38	10	29	16	93	
		3	4	13	10	26	131	1	26	83	1151	235	1683	812	120	539	212	1683	



Дүгнэлт:

Сүүлийн жилүүдэд хорих ангид ял эдэлж байгаа ялтнуудын дундаас хориотой эд зүйл болох гар утас ашиглах явдал таслан зогсоогдохгүй байгаа нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллагын тулгамдсан асуудал болоод байна.

Мөн Эрүүгийн хуулийн шинэтгэлийн хүрээнд ялын төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулагдаж байна. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “гэрийн хорио” гэсэн шинэ төрлийн ялыг бий болгохоор тусгасан бөгөөд уг ялаар шийтгүүлсэн ялтанд байр зүйн хяналт тогтоох хэрэгсэл /цахилгаан гав/ хэрэглэхээр төлөвлөжээ. Хийгдэж буй өөр томоохон шинэчлэлийн нэг нь хорих ял эдлүүлэх дэглэмийг олон улсын жишигт нийцүүлэн:

- Нээлттэй
- Хаалттай системд шилжүүлэх явдал юм.

Нээлттэй дэглэмтэй хорих ангид ял эдлэх ялтан нь хорих ангиас тогтоосон болон өөрийн сонгосон газраа харуул хамгаалалтгүйгээр ажиллах, өөрийн зардлаар их дээд сургуульд суралцах боломжтой байдаг бол хаалттай дэглэмтэй хорих ангид ял эдэлж буй ялтан зөвхөн гэрээний дагуу хорих ангиас заасан газарт харуул хамгаалалтын дор хөдөлмөрлөдөг.

Нээлттэй дэглэм бүхий хорих ангид ялтныг ял эдлүүлэх нь хорих ялаар шийтгэгдсэн ялтныг аль болох нийгэмд ойр байлгах, ажил, хөдөлмөр эрхлүүлэх замаар ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үздэг. Манай улсын хувьд хорих ял эдлүүлэх нээлттэй дэглэмд ял эдлэх ялтнуудад тавих хяналтыг хэрхэн

хэрэгжүүлэх талаар нарийвлан судлах шаардлагатай.

Хорих ял эдлүүлэх нээлттэй дэглэмийг дэлхий нийтийн жишигт нийцсэн байдлаар хэрэгжүүлэхийн тулд **нээлттэй дэглэмд ял эдлэх ялтнуудад байр зүйн хяналт тогтоох /цахилгаан гав, GPS хэрэглэх/ тогтолцоог бий болгох** нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь хорих ял эдэлж байгаа ялтнуудыг эзэнгүй /илрээгүй/ гэмт хэргийг үйлдсэн хэмээн сэжиглэх явдал элбэг тохиолддог төдийгүй, хяналтгүйгээр сул чөлөөтэй гадуур явдаг гэсэн шүүмжлэл байнга гардаг билээ. Нээлттэй хорих ангид ял эдлэх ялтнуудад GPS ашиглан байр зүйн хяналт тогтоох нь дараах ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Үүнд:

1. Хорих ангийн хамгаалалтын албаны үйл ажиллагааг хөнгөвчилнө.
2. Ялтан нийгэм дунд ажиллаж хөдөлмөрлөх, сурч боловсрох боломжтой болох бөгөөд энэ нь ялтныг нийгэмшүүлэхэд ажилд чухал ач холбогдолтой.
3. Биечилсэн хяналт тавихгүй байснаар ялтны сэтгэл зүйд төдийгүй түүний хүмүүжилд нь эерэг нөлөөлөл үзүүлнэ.
4. Гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэх хардлага үгүй болж Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах харилцаа сайжирна.
5. Ялтны хөдөлгөөнийг бүрэн хянах боломж бүрдэнэ гэх мэт.

Дэвшүүлж буй санал:

1. Хорих ангид ашиглаж буй харуул хамгаалалтын техник, тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийг сайжруулан хүрэлцээг нэмэгдүүлж хорих ангийн дотоод болон гадаад хэсэг, байршилыг бүрэн хяналтанд хамруулах. Түүнчлэн хорих ангийн удирдлага нууцыг чандлан хадгалж онлайнаар телехяналтыг хэрэгжүүлэх